

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Хэнтий-Ус ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2025/014/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хаяг:
www.open.audit.mn

Чингис хот
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 91913204 Цахим хаяг: ganbaatar@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунаа
Утас: 99195208 Цахим хаяг: ariunaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075
Утас: (976) 70518396

Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn

2025.03.17 № 282

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хэнтий ус ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар илэрсэн зөрчлүүд бидний тогтоосон шинж чанарын болон тоон дүнгээр илэрхийлсэн материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

1. Бараа материалын түүхий эд материал-9 данс (түлээний мод)-ны тайлан гаргаагүй, засварын материал, аж ахуйн материал, шатахууны тайланг гаргасан боловч өмнөх сарын эцсийн үлдэгдлийг дараа сарын эхний үлдэгдэлд зөрүүтэй тайлагнасан, гаргасан тайлангийн нийт орлого, зарлагын дүн тодруулгын тайлангийн дүнгээс зөрүүтэй.

2. Санхүүгийн байдлын тайлангаарх авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй.

3. Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 259 нэр төрлийн 1,349.2 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, 20.2.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2, 6.2.1, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын “үнэлгээ ба хуваарилалт”, “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Хэнтий-Ус ХХК нь 9,171.6 сая төгрөгийг орлого бүрдүүлж, 9,107.9 сая төгрөгийг зарцуулж, 63.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Тайлант онд урт хугацаат дамжуулан зээлдэх зээлийн 536.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс төлсөн.

Аудитын гол асуудал

Хэнтий-Ус ХХК тайлант онд ашигтай ажилласан нь урт хугацаат дамжуулан зээлдэх зээлийн 536.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс төлсөн, урьдчилж орсон орлогыг уг дансанд бүртгэлтэй улс, орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, төсөл хөтөлбөрөөр үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгийн тайлант оны элэгдлийн 109.9 сая төгрөгөөр бууруулсантай холбоотойгоор орлого нэмэгдсэн байна.

Тус компанийн Бэрх салбарт дулааны станц шинээр ашиглалтанд орсонтой холбоотойгоор шинэ техник, тоног төхөөрөмж бүхий ажлын байранд мэргэжлийн боловсон хүчнийг өндөр цалин хөлстэй ажиллуулах шаардлага үүссэн нь цалингийн зардал нэмэгдэх нөхцөл бүрдүүлж байгаа тул уг асуудлыг зохистой зохицуулж, төсөв, санхүүгийн төлөвлөлтөд анхаарч ажиллах шаардлагатай.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын Төлөөлөн удирдах зөвлөл 2023 оны 12 дугаар сард хуралдаж 2024 оны орон тоо, цалингийн санг баталсан боловч 2024 оны 8 дугаар сард дахин хуралдаж, цалин нэмэгдүүлэх шийдвэр гаргасан нь санхүүгийн төлөвлөлийн тогтвортой байдал, эдийн засгийн үр ашигт нөлөөлөх эрсдэлийг бий болгож байна. Иймд компанийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан цалингийн түвшнийг бодитой тодорхойлох шаардлагатай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	30,976,575,729.35	35,677,664,306.31
1.1	Эргэлтийн хөрөнгө	760,813,506.25	605,878,326.27
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	193,408,937.51	50,197,297.60
1.1.2	Дансны авлага	213,067,939.87	237,247,927.84
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	43,158,676.77	0.00
1.1.4	Бусад авлага	9,808,830.00	14,891,922.70
1.1.6	Бараа материал	298,569,122.10	302,408,190.50
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/Тооцоо	2,800,000.00	1,132,987.63
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	760,813,506.25	605,878,326.27
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	30,215,762,223.10	35,071,785,980.04
1.2.1	Үндсэн хөрөнгө	30,215,382,223.10	35,071,405,980.04
1.2.2	Биет бус хөрөнгө	380,000.00	380,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	30,215,762,223.10	35,071,785,980.04
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	30,976,575,729.35	35,677,664,306.31
2	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	30,976,575,729.35	35,677,664,306.31
2.1	ӨР ТӨЛБӨР	21,730,494,525.87	26,367,894,810.50
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	8,951,392,186.91	13,946,843,852.92
2.1.1.1	Дансны өглөг	1,012,268,438.19	485,313,759.29
2.1.1.3	Татварын өр	169,788,331.47	438,803,201.82
2.1.1.5	Богино хугацаат зээл	293,333,000.00	221,804,580.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	7,285,042,248.40	12,565,795,045.52
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	190,960,168.85	235,127,266.29
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	8,951,392,186.91	13,946,843,852.92
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	12,779,102,338.96	12,421,050,957.58
2.1.2.1	Урт хугацаат зээл	1,145,645,374.27	754,997,774.27
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	11,633,456,964.69	11,666,053,183.31
2.2	Өр төлбөрийн нийт дүн	21,730,494,525.87	26,367,894,810.50
2.3	Эзэмшигчдийн өмч	9,246,081,203.48	9,309,769,495.81
2.3.1	Өмч: - төрийн	8,644,662,384.67	8,644,662,384.67
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,675,409,524.20	1,675,409,524.20
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	364,616,130.00	364,616,130.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,438,606,835.39)	(1,374,918,543.06)
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	(1,274,187,427.53)	63,688,292.33
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	(164,419,407.86)	(1,438,606,835.39)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	9,246,081,203.48	9,309,769,495.81
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	30,976,575,729.35	35,677,664,306.31

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/ төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	5,767,416,553.96	7,758,276,407.29
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	8,087,074,547.60	8,593,245,093.40
3	Нийт ашиг (алдагдал)	(2,319,657,993.64)	(834,968,686.11)
8	Бусад орлого	712,400,000.00	712,880,000.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	14,560,337.86	26,842,407.40
10	Ерөнхий ба удирдлагын зардал	465,642,000.42	487,818,099.69
17	Бусад ашиг (алдагдал)	813,272,904.39	700,437,485.53
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(1,274,187,427.53)	63,688,292.33
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(1,274,187,427.53)	63,688,292.33
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(1,274,187,427.53)	63,688,292.33
24	Орлогын нийт дүн	(1,274,187,427.53)	63,688,292.33

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2023 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл	10,320,071,908.9	364,616,130.0	(164,419,407.9)	10,520,268,631.0
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(1,274,187,427.5)	(1,274,187,427.5)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт		-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-
2024 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл	10,320,071,908.9	364,616,130.0	(1,438,606,835.4)	9,246,081,203.5
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	63,688,292.3	63,688,292.3
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт		-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-
2025 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	10,320,071,908.9	364,616,130.0	(1,374,918,543.1)	9,309,769,495.8

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,775,054,874.8	8,961,192,783.7
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	6,118,510,303.1	8,157,632,100.7
	Татаас, санхүүжилтийн орлого	632,400,000.0	712,880,000.0
	Бусад мөнгөн орлого	24,144,571.8	90,680,683.0
1.2	Мөнгөн зарлага (-)	6,643,624,621.2	8,953,968,610.7
	Ажиллагчдад төлсөн	1,917,574,052.0	2,565,357,469.7
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	600,134,189.8	807,950,151.8
	Бараа материал худалдан авахад төлсөн	1,593,515,088.9	1,774,012,011.6
	Ашиглалтын зардалд төлсөн	781,726,214.4	994,203,773.2
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	835,311,598.3	1,610,949,516.4
	Хүүний төлбөрт төлсөн	20,117,032.0	37,627,927.8
	Татварын байгууллагад төлсөн	356,774,869.4	626,860,197.4
	Даатгалын төлбөрт төлсөн	4,060,000.0	3,990,000.0
	Бусад мөнгөн зарлага	534,411,576.5	533,017,562.9
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	131,430,253.6	7,224,172.9
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	549,457.1	338,532.2
	Хүлээн авсан хүүний орлого	549,457.1	338,532.2
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	382,879,292.0	79,245,925.0
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	382,879,292.0	79,245,925.0
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(382,329,834.9)	(78,907,392.8)
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	320,000,000.0	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	320,000,000.0	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	26,667,000.0	71,528,420.0
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	26,667,000.0	71,528,420.0
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	293,333,000.0	(71,528,420.0)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	42,433,418.7	(143,211,639.9)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	150,975,518.8	193,408,937.5
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	193,408,937.5	50,197,297.6

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/ мянган төгрөгөөр /

Зардлын ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Үйл ажиллагааны орлого	8,118,377.4	5,767,416.6	140,480.9
Үйл ажиллагааны бус орлого	2,154,947.9	1,045,470.0	244,191.0
Нийт орлогын дүн	10,273,325.3	6,812,886.6	384,671.9
Үндсэн үйл ажиллагааны зардал	10,194,984.5	7,880,300.0	1,515,426.1
Үндсэн үйл ажиллагааны бус зардал	78,340.8	207,774.0	144,433.2
Нийт зардлын дүн	10,273,214.3	8,088,074.0	1,659,859.3
Ашиг, алдагдал	-	- 1,275,187.4	-1,275,187.4

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 735,893.1 мянган төгрөгийн 5 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

-Үндсэн хөрөнгийн дансанд бараа, үйлчилгээний үйлдвэрлэлд ашиглах боломжгүй, биетээр оршин байхгүй их засварын зардлыг дуусаагүй барилга дансанд бүртгэснийг холбогдох байгууламжид капиталжуулав.

-Хэрлэн сумаас үнэ төлбөргүй нийлүүлсэн цэвэрлэх байгууламжийн ариутгалын бодисыг бараа материалын тайланд өглөгөөр бүртгэн, өглөгийг зардалд хаасныг орлогоор бүртгэв.

-Санхүүгийн байдлын тайланд 43,158.7 мянган төгрөгийн НӨАТ-ын урьдчилгааг авлагад, 215,861.9 мянган төгрөгийн НӨАТ-ын өглөгийг богино хугацаат өр төлбөрт бүртгэснээр авлага, өглөгийг нэмэгдүүлснийг нэг дансанд нэгтгэсэн.

-Тайлант онд урт хугацаат зээлийн дамжуулан зээлдэх гэрээний төлбөрт төлөгдсөн зээл, зээлийн хүүгийн төлбөрийг бүртгэлд тусгаагүй орхигдуулсныг зээлийн үндсэн төлбөрөөс бууруулж залруулав.

-Урьдчилж орсон орлого дансанд бүртгэгдсэн улс, орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, төсөл хөтөлбөрөөр үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгөнд элэгдэл тооцоогүйг нөхөж тооцуулж, залруулга хийлгэв.

Аудитаар нийт 162,962.5 мянган төгрөгийн 4 зөрчил² илэрснээс, 162,962.5 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж хүргүүлээ.

3.1 Албан шаардлага:

Тайлант онд 26,007.1 мянган төгрөгийн авлага, 68,986.7 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчжээ.

Бараа материалын тодруулгын тайланг эд хариуцагчийн цаасаар гаргасан тайлантай тулгахад түүхий эд материал-9 данс (түлээний мод)-ны тайлан гаргаагүй, засварын материал, аж ахуйн материал, шатахууны тайланг гаргасан боловч өмнөх сарын эцсийн үлдэгдэл дараа сарын эхний үлдэгдэлд зөрүүтэй тайлагнасан, гаргасан тайлангийн нийт орлого, зарлагын дүн тодруулгын тайлангийн дүнгээс зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан тасралтгүй байх зарчим, 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." гэсэн заалтууд зөрчигдсөн байна.

Халуун усны борлуулалтын 8,897.1 мянган төгрөгийн орлогод НӨАТ-ын баримт олгоогүй нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно” гэснийг зөрчсөн бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.2 Зөвлөмж

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 259 нэр төрлийн 1,349,228.3 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна", 6.2.1-д "Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон", "үнэлгээ ба хуваарилалт", "иж бүрэн байх", "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн дансны элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгийн жагсаалтыг гарган аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэн шийдвэрлүүлж, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгөнд их засварын зардал бүртгэсэн	1	34,739.4			1	34,739.4	1	34,739.4				
Үнэ төлбөргүй орлого буруу бүртгэсэн	1	11,900.0			1	11,900.0	1	11,900.0				
НӨАТ-ын тооцоог авлага, өглөгийн данс нэмэгдүүлж бүртгэсэн	1	43158.7			1	43158.7	1	43158.7				
Урт хугацаат зээлийн төлөлт бүртгэгдээгүй	1	536,161.0	1	536,161.0			1	536,161.0				
Урьдчилж орсон орлого дансны хөрөнгөнд элэгдэл дутуу байгуулсан	1	109,934.0	1	109,934.0			1	109,934.0				
Дүн	5	735,893.1	2	646,095.0	3	89,798.1	5	735,893.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Авлага, өглөгийн тооцоо нийлээгүй	1	94,994.0			1	94,994.0						
Бараа материалын тайлан зөрүүтэй	1	59,071.4			1	59,071.4						
Өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлэх	1	-					1	-				
Борлуулалтын орлогод НӨАТ-ын баримт олгоогүй	1	8,897.1			1	8,897.1						
Дүн	4	162,962.5			3	162,962.5	1	-				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Дүн										
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дүн										
Нийт дүн										